



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/106/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2110

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ДАРГА Д.УУГАНБАЯР
ТАНАА

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\2022 он пармаа\гэрчилгээ\A4-toot.docx



005000000

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,507,003.46	71,788,243.98
33	АВЛАГА	0.00	270.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	270.00
35	БАРАА МАТЕРИАЛ	51,507,003.46	71,787,973.98
351	Түүхий эд материал	6,634,308.00	26,969,613.00
35110	Тусгай зориулалттай материал	6,165,308.00	26,671,663.00
35130	Эм боох материал	469,000.00	297,950.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	6,000,000.00	0.00
354	Хангамжийн материал	38,872,695.46	44,818,360.98
35410	Бичиг хэргийн материал	1,614,560.00	1,655,350.00
35420	Аж ахуйн материал	22,520,101.00	22,843,025.00
35430	Сэлбэг хэрэгсэл	93,000.00	93,000.00
35440	Түлш, шатах тослох материал	505,000.00	545,000.00
35450	Барилгын засварын материал	0.00	7,435,000.00
35460	Хүнсний материал	3,379,868.46	334,019.98
35470	Бусад хангамжийн материал	10,760,166.00	11,912,966.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,234,876,337.02	1,217,312,443.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,234,876,337.02	1,217,312,443.82
392	Биет хөрөнгө	1,117,027,693.44	1,095,232,710.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,121,586,711.54	1,127,586,711.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,757,789.44)	(173,378,938.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,813,725.00	147,813,725.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(98,697,058.99)	(111,758,169.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,645,375.65	145,988,375.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,518,353.06)	(80,233,193.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,995,356.00	81,995,356.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,825,421.26)	(47,566,304.34)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,715,148.00	4,715,148.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	70,000.00	70,000.00
393	Биет бус хөрөнгө	117,848,643.58	122,079,733.30
39301	Программ хангамж	6,417,692.31	6,417,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,390,448.73)	(2,159,359.01)
39303	Бусад биет бус хөрөнгө	117,821,400.00	117,821,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,286,383,340.48	1,289,100,687.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,286,383,340.48	1,289,100,687.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,286,383,340.48	1,289,100,687.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	221,624,669.45	221,624,669.45
51101	Өмч: - төрийн	221,624,669.45	221,624,669.45
512	Хуримтлагдсан үр дүн	633,728,560.56	636,445,907.88
51210	Өмнөх үеийн үр дүн	633,728,560.56	633,728,560.56
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	2,717,347.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,030,110.47	431,030,110.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,286,383,340.48	1,289,100,687.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	647,759,595.00	713,854,387.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,368,895.00	56,062,787.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,368,895.00	56,062,787.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,368,895.00	56,062,787.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	210,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,228,895.00	55,852,787.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,390,700.00	657,791,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	632,390,700.00	634,551,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	632,390,700.00	634,551,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	23,240,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	22,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	440,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	720,678,277.96	711,137,039.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	720,678,277.96	711,137,039.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	718,215,184.64	708,664,340.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,299,867.92	461,781,597.91
210101	Үндсэн цалин	286,566,567.92	303,751,437.91
210102	Нэмэгдэл	162,055,300.00	155,091,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,178,000.00	2,938,260.00
210104	Урамшуулал	1,500,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,289,791.77	10,274,454.16
210201	Тэтгэврийн даатгал	245,803.26	738,059.36
210202	Тэтгэмжийн даатгал	26,026.23	86,827.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,026.23	111,333.76
210204	Ажилгүйдлийн даатгал	5,783.62	17,366.11
210205	Эрүүл мэндийн даатгал	8,986,152.43	9,320,867.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,713,522.47	82,334,014.95
210301	Гэрэл, цахилгаан	12,555,875.22	12,075,522.95
210302	Түлш, халаалт	62,736,455.25	61,790,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,421,192.00	8,468,492.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,234,467.50	16,567,432.55
210401	Бичиг хэрэг	1,737,190.00	2,504,510.00
210402	Тээвэр, шатахуун	13,430,300.00	9,920,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,987,582.50	2,585,922.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,327,040.00	1,107,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	9,554,355.00	0.00
2105	Нормативт зардал	46,853,012.42	44,621,356.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,329,250.00	2,136,450.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	45,523,762.42	41,901,058.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	583,848.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,775,190.00	3,378,256.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	318,400.00	0.00
210604	Урсгал засвар	7,456,790.00	3,378,256.00
210702	Дотоод албан томилолт	264,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,963,252.02	10,025,935.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,334,500.00	7,639,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	741,764.00	612,956.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	79,178.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,174,290.02	1,147,139.00
210807	Газрын төлбөр	333,520.00	237,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,822,080.54	79,681,293.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	534,000.00	404,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	610,000.00	259,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,678,080.54	79,016,893.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,463,093.32	2,472,699.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	336,000.00	252,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	336,000.00	252,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,939,500.00	1,989,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,939,500.00	1,989,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,593.32	231,699.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,593.32	231,699.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(72,918,682.96)	2,717,347.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(72,918,682.96)	2,717,347.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	637,530,700.00	659,177,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,000.00	1,386,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,000.00	1,386,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	210,000.00
120009	Бусад орлого	0.00	1,176,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,390,700.00	657,791,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	632,390,700.00	634,551,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	632,390,700.00	634,319,900.57
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	23,240,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	22,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	440,000.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	635,010,700.00	636,527,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635,010,700.00	636,527,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	632,547,606.68	634,054,900.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,299,867.92	462,957,597.91
210101	Үндсэн цалин	286,566,567.92	304,927,437.91
210102	Нэмэгдэл	162,055,300.00	155,091,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,178,000.00	2,938,260.00
210104	Урамшуулал	1,500,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,289,791.77	10,274,724.16
210201	Тэтгэврийн даатгал	0.00	738,059.36
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	86,827.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	111,333.76
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	17,366.11
210205	Эрүүл мэндийн даатгал	9,289,791.77	9,321,137.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,713,522.47	82,334,014.95
210301	Гэрэл, цахилгаан	12,555,875.22	12,075,522.95
210302	Түлш, халаалт	62,736,455.25	61,790,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,421,192.00	8,468,492.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,178,782.50	15,691,072.55
210401	Бичиг хэрэг	1,601,400.00	1,917,250.00
210402	Тээвэр, шатахуун	13,185,300.00	9,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,987,582.50	2,585,922.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,206,500.00	1,217,900.00
2105	Нормативт зардал	48,919,200.00	39,812,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,157,200.00	1,018,200.00
210502	Хоол, хүнс	47,762,000.00	38,793,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,775,190.00	11,133,256.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	318,400.00	320,000.00
210604	Урсгал засвар	7,456,790.00	10,813,256.00
2107	Томилолт, зочны зардал	264,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	264,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,963,252.02	10,465,935.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,334,500.00	8,079,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	741,764.00	612,956.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	79,178.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,174,290.02	1,147,139.00
210807	Газрын төлбөр	333,520.00	237,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,144,000.00	1,386,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	534,000.00	1,126,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	610,000.00	259,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,463,093.32	2,472,699.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	336,000.00	252,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	336,000.00	252,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,939,500.00	1,989,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,939,500.00	1,989,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,593.32	231,699.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,593.32	231,699.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,520,000.00	22,650,000.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,520,000.00	22,650,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,520,000.00	22,650,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,520,000.00	22,650,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	2,520,000.00	22,650,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,520,000.00	-22,650,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	706,647,243.52	1,359,302,023.44
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	706,647,243.52	1,359,302,023.44
C07	Тайлант үеийн үр дүн			-72,918,682.96	-72,918,682.96
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	633,728,560.56	1,286,383,340.48
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	560,809,877.60	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	633,728,560.56	1,286,383,340.48
D08	Тайлант үеийн үр дүн			2,717,347.32	2,717,347.32
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	636,445,907.88	1,289,100,687.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	634,761,600.00	634,529,900.57	231,699.43	99.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,761,600.00	634,529,900.57	231,699.43	99.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,586,300.00	633,464,900.57	121,399.43	99.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	462,975,100.00	462,957,597.91	17,502.09	100.00
210101	Үндсэн цалин	305,027,200.00	304,927,437.91	99,762.09	99.97
210102	Нэмэгдэл	155,091,900.00	155,091,900.00	0.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,224,000.00	2,938,260.00	1,714,260.00	240.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,280,400.00	10,274,724.16	5,675.84	99.94
210201	Тэтгэврийн даатгал	0.00	738,059.36	-738,059.36	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	86,827.50	-86,827.50	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	111,333.76	-111,333.76	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	17,366.11	-17,366.11	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,280,400.00	9,321,137.43	959,262.57	90.67

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,367,800.00	82,334,014.95	33,785.05	99.96
210301	Гэрэл, цахилгаан	12,109,200.00	12,075,522.95	33,677.05	99.72
210302	Түлш, халаалт	61,790,000.00	61,790,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	8,468,600.00	8,468,492.00	108.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,696,200.00	15,691,072.55	5,127.45	99.97
210401	Бичиг хэрэг	1,794,400.00	1,917,250.00	-122,850.00	106.85
210402	Тээвэр, шатахуун	9,520,600.00	9,520,000.00	600.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,589,300.00	2,585,922.55	3,377.45	99.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,900.00	450,000.00	122,900.00	78.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,219,000.00	1,217,900.00	1,100.00	99.91
2105	Нормативт зардал	39,812,000.00	39,812,000.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,018,200.00	1,018,200.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	38,793,800.00	38,793,800.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,934,000.00	15,933,256.00	744.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,800,000.00	4,800,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320,000.00	320,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	10,814,000.00	10,813,256.00	744.00	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,784,500.00	5,725,935.00	58,565.00	98.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,341,600.00	3,339,900.00	1,700.00	99.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	613,000.00	612,956.00	44.00	99.99
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,175,000.00	1,147,139.00	27,861.00	97.63
210807	Газрын төлбөр	266,900.00	237,940.00	28,960.00	89.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	736,300.00	736,300.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	476,500.00	476,500.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	259,800.00	259,800.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,175,300.00	1,065,000.00	110,300.00	90.62
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	362,000.00	252,000.00	110,000.00	69.61
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	362,000.00	252,000.00	110,000.00	69.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	813,300.00	813,000.00	300.00	99.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	813,300.00	813,300.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	634,761,600.00	634,529,900.00	231,700.00	99.96
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	634,551,600.00	634,319,900.00	231,700.00	99.96
131001	Улсын төсвөөс санхүүжих	634,551,600.00	634,319,900.00	231,700.00	99.96
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	210,000.00	210,000.00	0.00	100.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	210,000.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35.00	35.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000,000.00	23,240,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000.00	23,240,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00	23,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17,850,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	17,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	4,740,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	4,740,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	650,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,000,000.00	23,240,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	23,240,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	22,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	440,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 1/56 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд газрын дарга хурандаа Д.Ууганбаяр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Н.Доржсүрэн нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тус газар нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2021 онд дэвшүүлсэн зорилт”-ын хүрээнд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлж удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахад чиглэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 720,678.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,810.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,648.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 8,533.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,717.3 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,507.00	71,788.20	20,281.20
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	-	-	0.00
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	51,507.00	71,787.90	20,280.90
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,234,876.30	1,217,312.40	-17,563.90
Үндсэн хөрөнгө	1,576,065.40	1,631,408.40	55,343.00
Хуримтлагдсан элэгдэл	-77,678.10	-79,016.80	-1,338.70
Нийт хөрөнгө	1,286,383.30	1,289,100.60	2,717.30
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,286,383.30	1,289,100.60	2,717.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,286,383.30	1,289,100.60	2,717.30

Бараа материалын дансны үлдэгдэл 71,787.9 мянган төгрөг болж 20,280.9 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дансны үлдэгдэл өмнөх оноос 20,507.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дээд шатны төсөв захирагчаас шилжүүлж хөрөнгө орлогоор авсан нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,631,408.4 мянган төгрөг болж 55,343.0 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021.01.26-ны өдрийн 15 тоот тогтоол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2021.02.04-ний өдрийн 06/285 тоот албан бичгийн дагуу санхүүгийн программ, шийдвэр гүйцэтгэлийн программыг тус тус ашиглах жилийг сунгах, үнэ шинэчлэх ажлыг зохион байгуулж 5,110.0 мянган төгрөгөөр орлогоор авч, данснаас хассан байна. Мөн 3,900.0 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн хяналтын төхөөрөмж /Ipad/, 23,793.0 мянган төгрөгийн цахилгаан үүсгүүр /24кВт/30кВа/ шилжүүлэн авч орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,100.0 мянга, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5,040.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд орлогоор бүртгэж бүртгэл тайланд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,289,100.6 мянган төгрөг болж 2,717.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,717.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 613,351.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 613,351.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,410.3 мянган төгрөгөөр бууруулж 619,500.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 11 дүгээр сард төсөвт зохицуулалт хийгдэж 634,761.1 мянган төгрөг болж 15,260.7 мянган төгрөг буюу 2.4 хувиар буурч батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 634,761.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 634,761.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 364,761.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 634,529.9 мянган төгрөгийг зарцуулж 231.6 мянган төгрөг буюу 0.03 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 634,529.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь засгийн газрын дотоод шилжүүлэг 110.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 121.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн 3/10 тоот тогтоол, Аймгийн засаг даргын 2021.08.02-ны өдрийн А/477 тоот захирамжаар тус газрын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж авахад шаардагдах зардалд 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон, Хууль зүй дотоод хэргийн яамнаас өршөөлийн хуулийн хэрэгжилт зарцуулах зардалд 440.0 мянга, аймгийн ИХТ-ын 2021.11.10-ны өдрийн 23 тоот ИТХ-ын даргын захирамжаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий байгууллагын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд 1,000.0 мянга, Засаг даргын 2021.11.04-ны өдрийн А/681 тоот

захирамжаар тус газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардалд 1,000.0 мянга, 2021.01.01-ны өдрөөс хэрэгжиж буй “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг хуулийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах зардалд 800.0 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэн 23,240.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 10030012401 тоот дансаар олгосон бөгөөд 21,805.0 төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд олгосон 1,000.0 мянга, үйл ажиллагааны зардалд олгосон 435.0 мянга нийт 1,435.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай хууль хэрэгжиж эхэлж байгаатай холбоотойгоор Дээд шатны төсөв захирагчаас 308.0 мянган төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг гар станц, 84.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг гав, 390.0 мянган төгрөгийн мансууруулах бодис, 171.0 мянган төгрөгийн 3 ширхэг бүстэй гав, 19,552.5 мянган төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг цахим бугуйвч /гав/ үнэ төлбөргүй шилжүүлэн ирснийг данс бүртгэлд орлогоор бүртгэн хүлээн авсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 46 ажлыг төлөвлөж, хэрэгжилт 95.1%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 711,137.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 9,541.2 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, хангамжийн материал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг дагуу шилэн дансны нэгдсэн системд нийт 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан боловч Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр байршуулахдаа зардлыг өссөн дүнгээр буюу 41,167.0 мянган төгрөгийн гүйлгээг давхардуулан байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	96	0	0
	Нийт	27	151	149	0	2

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр байршуулахдаа зардлыг өссөн дүнгээр буюу 41,167.0 мянган төгрөгийн гүйлгээг давхардуулан мэдээлсэн нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

Мөн 2021 онд Албан хаагч, хоригдогсдын хоол, хүнсний материал нийлүүлэх 83,555.8 мянга, Шатах тослох материалыг нийлүүлэх 10,985.3 мянган төгрөгийн үнэ бүхий тендерийг <http://tender.gov.mn/> хаягт байршуулан зарласан ба тендерийн үнэлгээний хороог тус газрын даргын 2021.01.05-ны өдрийн А/02 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Тендерт шалгаруулалтын материалтай танилцахад Софтвишин ХХК, Лэгдэн хангай ХХК гэсэн 2 аж ахуй нэгж оролцсон байна. Тус үнэлгээний хороо нь тендер шалгаруулалт зохион байгуулахдаа тендерийн үнэлгээний хуудсыг бөглөөгүй, тендерийн бичиг баримт бичгийн бүрдэл дутуу, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг алдаа зөрчил байна. Тендерийн 1-р багцад гадаа худалдаа, гэр ахуй, гоо сайхны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий Лэгдэн Хангай ХХК-нийг шалгаруулж гэрээ байгуулах зөвлөмжийг 2021.02.09-ны өдөр Баянхонгор аймаг дахь ШШГГазрын даргад хүргүүлсэн байна. Дээрх ААНБ нь Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаггүй, борлуулалтын цэг болон борлуулагч байхгүй, үйл ажиллагааны чиглэлд нь хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэггүй байхад мах, махан бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх 36,416.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж 26,700.0 мянган төгрөгийн хүнс, 470.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,435.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч төсвийг зориулалтын дагуу зарцуулах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах мөн аж ахуй нэгж байгууллагатай хийсэн гэрээний хэрэгжилтийг дүгнэж байх, хүнсний материал худалдан авахдаа бараа материалыг хүлээлцсэн акт үйлдэн анхан шатны баримтад хавсаргах, хяналтыг сайжруулах, шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийн хуулийн хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлж байх 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Зөвлөмж

4.2.1 Баянхонгор аймаг дахь ШШГГазрын 2021 онд Албан хаагч, хоригдогсдын хоол, хүнсний материалыг нийлүүлэх тендерийг <http://tender.gov.mn/> хаягт байршуулан зарласан тус тендерт шалгаруулалтын материалтай танилцахад Софтвишин ХХК, Лэгдэн хангай ХХК гэсэн 2 аж ахуй нэгж оролцсон байна. Тус үнэлгээний хороо нь тендер шалгаруулалт зохион байгуулахдаа тендерийн үнэлгээний хуудсыг бөглөөгүй, тендерийн бичиг баримт бичгийн бүрдэл дутуу, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг алдаа зөрчил байна. Тендерийн 1-р багцад гадаа худалдаа, гэр ахуй, гоо сайхны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий Лэгдэн Хангай ХХК-нийг шалгаруулж гэрээ байгуулах зөвлөмжийг 2021.02.09-ны өдөр Баянхонгор аймаг дахь ШШГГазрын даргад хүргүүлсэн байна. Дээрх ААНБ нь Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаггүй, борлуулалтын цэг болон борлуулагч байхгүй, үйл ажиллагааны чиглэлд нь хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэггүй байхад мах, махан бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх 36,416.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж 26,700.0 мянган төгрөгийн хүнс, 470.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27, 28 дугаар зүйлийн зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг тухай бүр нь холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлж байх

4.2.2 Тайлант онд Софтвишин ХХК, Лэгдэн хангай ХХК худалдан авалт хийхээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, хүнсний материал худалдан авахдаа бараа материалыг хүлээлцсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 49 дүгээр зүйлийн “49.1.Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, “49.2.10.гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аж ахуй нэгж байгууллагатай хийсэн гэрээний хэрэгжилтийг дүгнэж байх, хүнсний материал худалдан авахдаа бараа материалыг хүлээлцсэн акт үйлдэн анхан шатны баримтад хавсаргаж байх.

4.2.3 Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн хугацаанд нь байршуулсан боловч Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр мэдээлэхдээ зардлыг өссөн дүнгээр буюу 41,167.0 мянган төгрөгийн гүйлгээг давхардуулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4. “Энэ хуулийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4. “Энэ хуулийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэсэн хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг үнэн зөв мэдээлж байх.

4.2.4 Аймгийн Засаг даргын А/681 дүгээр захирамжаар байгууллагын үйл ажиллагаанд зарцуулахаар олгосон 1,000.0 мянга, аймгийн ИТХ-ын даргын 23 дугаар захирамжаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар олгосон 1,000.0 мянга нийт 2,000.0 мянган төгрөгийг ШШГГ-н даргын 2021.11.17 өдрийн Б/24 тоот тушаалаар нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зардал зарцуулахаар заасан боловч нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан нотлох баримт байхгүй 30 жилийн ой баяр тэмдэглэхэд зарцуулж, хоол хүнсний зардалд 1,435.0 мянга, видео контент хийхэд 565.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн “46.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай зарцуулах төсвийн хөрөнгөөр ой болон тэмдэглэлт арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	4	1,435.0	0	0	0	0	0	0	4	1,435.0

_____оОо_____